

ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ХЯНАЛТЫН НИЙТИЙН СОНСГОЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04 дүгээр сарын 05

№: 01

Хужирт сум

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал “Хоршоо хөгжүүлэх сангийн 2022 оны төсвийн хяналт” сэдвээр 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 11 цагаас сумын соёлын төвд зохион байгуулсан нийтийн сонсголд дуудагдаж ирсэн албан тушаалтан Засаг даргын Тамгын газрын дарга З.Цэцэгмаа, Төсвийн ерөнхий нягтлан бодогч Д.Уранчимэг, хүнс, жижиг дунд үйлдвэр хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Доржсэмбэ, оролцогчоор Ц.Батдэлгэр, Ц.Долгормаа, Д.Бямбасүрэн, Ц.Пүрэвсүрэн, Х.Энхцэцэг, Л.Зориг, ажиглагчаар Д.Ганбаатар, Н.Оюунсүрэн, Б.Даваа, Б.Энхцэцэг, Б.Долгорсүрэн, Н.Сарантуяа, Б.Хажидмаа, Г.Нарантуяа, Ч.Цэцэгмаа нар оролцож сонсгол 11:10 минутад эхлэв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хоршоо хөгжүүлэх сангийн 2022 оны төсвийн хяналт

СОНССОН НЬ:

Ц.Галбадрах: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе! Хоршоо хөгжүүлэх сангийн 2022 оны төсвийн хяналтын сонсгол эхлэхэд бэлэн боллоо. Сонсгол удирдан явуулах сонсгол даргалагч Шунхлай 5 дугаар багийн Засаг дарга Ц.Лхамроломыг урьж байна.

Ц.Лхамролом: Сайн байцгаана уу? Өнөөдрийн сонсголын сэдэв Хоршоо хөгжүүлэх сангийн 2022 оны төсвийн зарцуулалт гэсэн сэдэв байгаа.

Та бүхэнд дуудагдаж ирсэн албан тушаалтнуудыг танилцуулъя. Сумын Засаг даргын Тамгын газрын дарга З.Цэцэгмаа, Төсвийн ерөнхий нягтлан бодогч Д.Уранчимэг, хүнс, жижиг дунд үйлдвэр хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Доржсэмбэ нар хүрэлцэн ирсэн байна.

Сонсголд оролцогчоор бүртгүүлсэн иргэдийг танилцуулъя. Өвөрмодот 1 дүгээр багийн иргэн Ц.Батдэлгэр, Уужим 2 дугаар багийн иргэн Ц.Долгормаа, Бэрх 3 дугаар багийн иргэн Д.Бямбасүрэн, Шивээт 4 дүгээр багийн иргэн Ц.Пүрэвсүрэн, Шунхлай 5 дугаар багийн иргэн Х.Энхцэцэг, Дулаан 6 дугаар багийн иргэн Л.Зориг нар оролцогчоор оролцоно.

Ажиглагчаар Д.Ганбаатар, Н.Оюунсүрэн, Б.Даваа, Б.Энхцэцэг, Б.Долгорсүрэн, Н.Сарантуяа, Б.Хажидмаа, Г.Нарантуяа, Ч.Цэцэгмаа нар оролцоно.

За та бүхэнд сонсголын дэгийг танилцуулъя. (Дэгийг хавсаргав)

Хоршоо хөгжүүлэх сангийн 2022 оны төсвийн зарцуулалтыг хүнс, жижиг дунд үйлдвэр хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Доржсэмбэ танилцуулна.

Б.Доржсэмбэ: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр хоршоо хөгжүүлэх сангийн зарцуулалтын талаар мэдээлэл өгнө. (Тайланг хавсаргав)

Ц.Лхамролом: За сонсголын сэдвээр танхимд ирсэн дарааллын дагуу 4 дүгээр багийн иргэн Ц.Пүрэвсүрэн асуулт, санал байвал хэлж болно.

Д.Бямбасүрэн: Асуулт, санал байхгүй ээ.

Д.Бямбасүрэн: Асуулт, санал байхгүй ээ.

Ц.Лхамролом: Дараагийн оролцогч 2 дугаар багийн иргэн Ц.Долгормаа асуулт, саналаа хэлээрэй.

Ц.Долгормаа: Асуулт байхгүй ээ.

Ц.Лхамролом: За дараагийн оролцогч 6 дугаар багийн иргэн Л.Зориг асуулт, саналаа хэлээрэй.

Л.Зориг: Сая танилцуулсан компаниудын үйл ажиллагааны чиглэлийг тодорхой хэлбэл зүгээр санагдаж байна. Төсөл сонгон шалгаруулах баг ихэнх нь бүсгүйчүүд байна. жендерийн тэгш байдал алдагдаж байна гэж бодож байна. Доржсэмбэ ганцаараа эрэгтэй байна гэсэн санал байна. Бас зээлийн эргэн төлөлт ямар байна вэ? Хяналт яаж тавьдаг вэ?

Ц.Лхамролом: За бүх оролцогчдоос асуулт саналаа авчхаад хариултаа сонсьё. Дараагийн оролцогч Пүрэвсүрэн саналаа хэлээрэй.

Ц.Пүрэвсүрэн: Санал байхгүй ээ.

Ц.Лхамролом: Та бүхэн асуултаа бас бичгээр өгч болно. Батдэлгэр эмч асуулт байна уу?

Батдэлгэр: Энэ аж ахуй нэгжүүд хаана юу хийдгийг нь сонсчихвол зүгээр санагдаж байна.

Ц.Лхамролом: За дараагийн оролцогч Х.Энхцэцэг эгч асуулт байна уу?

Х.Энхцэцэг: Би бас ямар компани ямар юу хийдэг вэ гэдгийг мэдмээр байна. Энэ дундаас Хужирт цагаан ХХК, Буман сувд ХХК хоёроос бусдыг нь мэдэхгүй байна.

Ц.Лхамролом: За өөр асуулт асуух оролцогч байхгүй бол Б.Доржсэмбэ асуултад хариулна.

Б.Доржсэмбэ: За зээл авсан аж ахуй нэгж нь сар сараар биш улиралд нэг буюу жилд дөрвөн удаа эргэн төлөлт хийдэг. Энэ таван аж ахуй нэгжийн эргэн төлөлт хэвийн явагдаж байгаа. Хяналтын хувьд сая танилцуулсан таван хүний бүрэлдэхүүнтэй баг улиралд нэг удаа хяналт тавиад явдаг зарчимтай. Зээл авсан аж ахуй нэгжүүдийг танилцуулбал Хужирт цагаан ХХК бол сүүн чихрийн үйлдвэр, Мөнхөд өрнөн дэлгэрэх хоршоо бол Баярсайхан гээд малын түүхий эд авдаг урд хороонд байдаг. Буман сувд ХХК нь талх нарийн боовны чиглэлээр үйлдвэрлэл явуулдаг Цэдэв захиралтай. Өгөөмөр Шунхлай ХХК нь Шинэнбат захиралтай ойн цэвэрлэгээ нөхөн сэргээлт чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Мөнх арцат хайрхан ХХК нь Мөнхдалай эзэнтэй талх нарийн боовны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Л.Зориг: Бизнес хөгжлийн төвд байдаг мөн үү?

Б.Доржсэмбэ: Тийм ээ. Одоо урагшаа шинэ байртай болоод нүүсэн байгаа. За ийм таван аж ахуй нэгж нэг хувийн хүүтэй зээлд хамрагдсан байгаа.

Л.Зориг: Хяналт улиралд нэг удаа тавьдаг гэсэн журам нь байгаа юу?

Б.Доржсэмбэ: Одоогоор байхгүй ээ. Журам нь 2021 онд шинэчлэгдсэн байгаа.

Л.Зориг: Энэ аж ахуй нэгжүүдийг сонгодог ажлын хэсэг байсан тэр хүмүүсийг яаж сонгодог вэ?

Б.Доржсэмбэ: Тендер сонгон шалгаруулах багийн бүрэлдэхүүнд журамд заасны дагуу Засаг даргын Тамгын газрын дарга, төрийн сангийн төлөөлөл, хоршоо жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр 3 -аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан хоёр төрийн бус байгууллагын төлөөлөл байх бөгөөд нарийн бичгийн даргаар Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн би байгаа. Дарга, төрийн сангийн төлөөлөл нарийн бичгийн дарга нь албан тушаалаараа орж ирж байгаа. Хоёр төрийн бус байгууллагын төлөөлөл гэхээр журмаараа жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх чиглэлээр гурваас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байх ёстой гэхээр манайд ийм төрийн бус байгууллага байхгүй. Одоо үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага гэхээр Хужирт илч, эмэгтэйчүүдийн холбоо байгаа. Энэ хоёр төрийн бус байгууллагаасаа сонгоод иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хурлаар ороод сонгогдсон бүрэлдэхүүн байгаа.

Л.Зориг: Төрийн бус байгууллагын төлөөллийг өөрчлөх боломж байгаа юу?

Б.Доржсэмбэ: Би өөрчлөх боломжгүй. Хурлаар ороод санал хураагаад шийддэг байгаа.

Л.Зориг: Журмаараа бол аймгийн мэргэжилтэн нь ирж байж л шалгалт хийх үү?

Б.Доржсэмбэ: Тийм ээ. Энэ хүн нь ирж зохион байгуулаад ажлын хэсэг хяналт хийдэг. Улирал бүр сумдад очиж хяналт тавиад явна гэсэн байдаг.

Л.Зориг: Хоршооны төлөөлөл солих гэж асуусан.

Б.Доржсэмбэ: Хоршооны хувьд улсын бүртгэлд бүртгүүлсэн манай сумын 13 хоршоо байдаг. Тогтвортой үйл ажиллагаа явуулдаг дөрвөн хоршоо байгаа. “Өгөөмөр шунхлай хоршоо”, “Мөнхөд өрнөн өсөх хоршоо” мөн 2 дугаар багийн иргэн Б.Орхон шинээр хоршоо байгуулж байгаа. Ерөнхийдөө улсын бүртгэлд бүртгэлтэй 13 хоршооноос 8 нь ямар ч идэвхгүй байгаа.

Л.Зориг: Дээр гишүүн зурагтаар гарахдаа хэлж байсан. Манай аймгийн нэрийг гаргадаг хоёр л брэнд бүтээгдэхүүн байна гэсэн. Хужирт ус, Сүүн чихэр хоёр байна. Сүүн чихрийг аймгийн хэмжээнд томхон зээлд хамруулбал зүгээр байна.

Б.Доржсэмбэ: Ноднин жил жижиг дунд үйлдвэрийг дэмжих зээлийн санд аймагт тэрбум төгрөг хуваарилагдаж ирсэн. Бид нар хоорондоо ярилцаад төслөө явуулсан боловч дэмжигдээгүй. Тэгээд сумаасаа хоршоо хөгжүүлэх сангаас зуун сая төгрөгийн зээл олгосон.

Л.Зориг: Аймгийн хэмжээнд төлөөлж байгаа шүү дээ. Тэгэхээр та бүхэн бас анхаарч үзэх хэрэгтэй гэж бодож байна.

Ц.Лхамролом: За санал хэлэх өөр оролцогч байна уу?

Х.Энхцэцэг: Зээл эргэн төлөх хугацаа нь хэдэн жил вэ?

Б.Доржсэмбэ: Таван жил хэвээрээ байгаа. 3 хувийн хүү хэвээрээ. Улиралд төлөлт хийх нь хэвээрээ байгаа.

Д.Бямбасүрэн: Зээл авсан иргэн дахиж зээл авч болох уу?

Б.Доржсэмбэ: Авсан зээлээ төлөөд дууссан бол дахиад авах боломжтой.

Х.Энхцэцэг: Хувь хүн төсөл бичиж болох уу?

Б.Доржсэмбэ: Болно. Энэ журам анх гарахдаа хоршоо болон жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуй нэгж гэж байсан. Шинэчлэгдээд иргэнд бас олгож болохоор болсон байгаа.

Л.Зориг: Манай сумын хэмжээнд хир их зээл олгосон бэ?

Б.Доржсэмбэ: 270,000,000 төгрөгийн хөрөнгө байгаа.

Л.Зориг Төслөө хэднийг хүртэл хүлээж авдаг вэ?

Б.Доржсэмбэ: Одоо 4 сарын 20 хүртэл хүлээж авна.

Д.Бямбасүрэн: Одоо үйл ажиллагаа явуулахад хориглох зүйл гэж байх уу?

Б.Доржсэмбэ: Одоо иргэдийн хурлаар оруулаад тухайн бүр нь тэргүүлэх чиглэлийг тогтоож өгдөг. Хуучин ирсэн бүх төслийг авдаг байсан бол одоо хурлын тогтоож өгснөөр хөдөө аж ахуй, хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төсөл хүлээн авна. Дараа нь 40,5 -аас дээш бүрдсэн тохиолдолд хурлаар дахиж оруулаад дэмжих чиглэлийг тогтоогоод тэр чиглэлийн дагуу тухай тухай бүр нь гарсан шийдвэрийн дагуу явдаг байгаа.

Л.Зориг: Энэ анхны сонсгол уу?

Ц.Галбадрах: Үгүй ээ. Гурав дах нийтийн сонсгол. Гэхдээ хоршоо хөгжүүлэх сангийн 2022 оны хяналтын чиглэлээр бол анхны сонсгол байгаа. Одоо орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны төсвийн зарцуулалтаар хяналтын сонсгол бас болно.

Л.Зориг: Хоршоо гэлтгүй бусад байгууллагууд ийм сонсгол хиймээр байгаа юм. Татвар, нийгмийн халамж, цагдаагийнх нь гэх мэт нийтийг хамруулаад ийм сонсгол хийж байвал зүгээр юм байна. баярлалаа.

Ц.Лхамролом: За өөр асуулт санал хэлэх оролцогч байхгүй бол нийтийн сонсголыг хааж байна. Энд хүрэлцэн ирсэн оролцогч, ажиглагчид болон дуудагдаж ирсэн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдадаа баярлалаа.

Сонсгол 12 цаг 25 минутад өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:
СОНСГОЛ ДАРГАЛАГЧ Ц.ЛХАМРОЛОМ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААН
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ЦЭНДХОРЛОО